

жүүлснээр харьцангуй богино хугацааны дотор Ази, Номхон далайн бүс нутгийн бусад оронтой эдийн засгийн үр бүтээлт харилцаа тогтоох талаар тодорхой үр дүнд хүрэх боломж байна.

АСЕАН-НЫ ОРНУУДЫН ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН АСУУДАЛД

Ч. Сувд

Сүүлийн үед «Шинэ үйлдвэржүүлэлтийн» хийгээд «Азийн залуу луунууд» хэмээн янз бүрээр нэрлэгдэж байгаа АСЕАН-ны орнууд олон улсын мэргэжилтэн, шинжлэн судлаачдын анхаарлыг гойд татах боллоо. Энэ нь санамсаргүй тохиолдол, өнгөц шохоорхол төдийхөн бус, харин ч зүй ёсны хэд хэдэн учир шалтгаантай, үлгэр жишээ авахуйц дууриалалтайд байгаа билээ.

Нийгмийн амьдралын бүх хүрээнд, тэр дундаас гадаад харилцаанд өөрчлөлт шинэчлэлт хийх зарчмыг дэвшүүлсэн МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлын (1988 оны) үзэл санааны үүднээс үзэх юм бол АСЕАН-ны орнуудын үйлдвэржүүлэлт нь манай орны хувьд тэргүүн туршлагын ч, үзүүлэх сургуулийн ч шинжтэй юм. Мэдээжээр манай орон нийгмийн байгуулал, газар зүйн байрлал, түүхэн уламжлал зэргээрээ АСЕАН-ны орнуудаас ихээхэн ялгаатай, гэхдээ хөгжиж яваа социалист орны аж үйлдвэржиж эхэлсэн орны хувьд адилсах тал, жиших зүйл байгаа нь эргэлзээгүй.

МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлын тогтоолд «...дэлхийн аж ахуйн хэлхээ холбоонд оновчтой оролцох замаар гадаад харилцаа ны үр өгөөжийг дээшлүүлэх нь чухал. гадаад бодлогын үйл ажиллагаанд тунхаглах, үзэл суртал, бусад ялгааг шалтаг болгох явдлыг

1. Мировая экономика и международные отношения, 1981, № 3, с. 73
2. Энэ тухай Kojima K, Japan and a Pacific Trade Area, Tokyo, 1971 - хэмээх номноос тодруулж үзнэ үү.
3. Kaneko K. A New Pacific Initiative: Strengthening the PECC Process. - Japan Review of International Affairs, Spring-Summer 1988, volume 2, n 1, p. 69
4. Энэ тухай «Тихоокеанское сообщество»: планы и перспективы, Москва, 1987, с. 70-86 тодруулж үзнэ үү.
5. An Asian-Pacific Regional Economic Organization: An Exploratory Concept Paper. Washington: US Government Printing Office. 1979, p. 19
6. «Тихоокеанское сообщество»: планы перспективы, Москва, 1987. с. 72
7. Interim Report on the Pacific Basin Cooperation Concept. Tokyo, 1979, p. 11
8. Nishikawa J. Towards Intensified Functional Cooperation in the Asia-Pacific Region. - The Challenge of Asia-Pacific Cooperation. Ed. by Fu-chen Lo, Kamal Salih. Association of Development Research and Training Institutes of Asia and the Pacific (ADIPA), Kuala Lumpur, 1987, p. 27
9. Far Eastern Economic Review, June 2, 1988, Volume 140, n 22, p. 59
10. Kaneko K., op. cit., p, 74-85

өөрчлөх нь зүйтэй»¹ гэж заасны дагуу АСЕАН-ны орнуудын үйлдвэржүүлэлтийн зарим асуудалд уншигч таны анхаарлыг хандуулъя.

Аж үйлдвэрийн өсөлт, хурдац. АСЕАН-ны бүрэлдэхүүнд ордог Малайз, Сингапур, Тайланд, Индонез, Филиппин нь колони, хагас колони орнууд байсан болохоор хөгжлийн хоцрогдол, эдийн засгийн хараат байдлын аль алиныг өвлөн авсан боловч дэлхийн хоёрдугаар дайны дараа хөгжил дэвшлийн замд зугуухан гарч, дал, наяд оны үед ирмүүн хөгжих хандлагыг олж авч чаджээ. Ялангуяа «хот-улс» хэмээн нэрлэгддэг Сингапур нь нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдээрээ дунд зэргийн хөгжилтэй капиталист орны тоонд нэгэнт тооцогдох түвшиндээ хүрсэн бол Малайз, Филиппин, Тайланд нь түүнд нэлээд дөхөж очоод байна. Харин Индонез нь хүн ам олонтой болохоор нэг хүнд ноогдох нийгмийн нийт болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүнээрээ доогуур боловч аж үйлдвэрийн чамлалтгүй нөөц бололцоотой болжээ.

Дэлхийн капиталист систем, тэр дундаас өндөр хөгжилтэй зонхилох долоон орны эдийн засгийг бүхэлд нь хийгээд үе хамарсан эрчим хүч, санхүү валютын хямрал болж тэр бүхний нөлөөгөөр АСЕАН ны орнуудад хүндрэл, бэрхшээл учирч байсан ч тэдгээр орнууд аж үйлдвэржиж, үлэмжхэн туршлага хуримтлуулж чадсаныг зүй ёсоор нь үнэлж цэгнэх хэрэгтэй юм. Тухайлбал 1960-1985 онд хөгжиж буй орнуудын боловсруулах үйлдвэрийн жилийн дундаж өсөлт 6,5 хувь байхад АСЕАН-ны орнуудынх 8,5 хувь байсан нь дэлхийд дээгүүрт орох өсөлт болно. Ялангуяа 1960—1970 онд дурьдсан үзүүлэлт - АСЕАН-ны орнуудад 9,2; хөгжиж буй орнуудад 7,1; харин 1970—1980 онд 10,4; 6,8 байсны дотор Малайз, Сингапур, Тайландад арваас илүү гарч байлаа.² Харин 80-аад оноос аж үйлдвэрийн өсөлтийн хурдац гурав дахь орнуудын хэмжээнд ч Зүүн Өмнөд Азийн бүс нутагт ч буурах тийшээ хандлаа. Жишээ нь 1980—1985 онд өмнөх арван жилийнхтэй харьцуулахад боловсруулах аж үйлдвэрийн жилийн дундаж өсөлт Сингапурт 4,6, Индонезид 2,0, Малайзид 1,9 дахин, Филиппинд мэдэгдэхүйц хэмжээгээр буурчээ. Үүний улмаас АСЕАН-ны орнуудын хоорондын ялгаа багасхаасаа ихсэхэд хүрснийг нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өөрчлөлтөөс харж болно.

**Боловсруулах аж үйлдвэрийн цэвэр бүтээгдэхүүний
зориулалтаараа (хувиар-)
нэг хүнд ноогдох бүтээгдэхүүн (Америк доллар) зэрэгцүүлэх үнээр**

	1960	1984
1. АСЕАН Үүнээс	83	479
Индонез	18	83
Малайз	72	442
Сингапур	206	1542
Тайланд	33	167
Филиппин	84	162
2. Хөгжиж буй орнууд	74	159
3. Хөгжингүй кап. орнууд	1424	2986

* АСЕАН-д сүүлд нь элссэн Бруней нь хүн амын тоо, байгалийн баялаг, нэг хүнд ноогдох орлогоороо бусдаасаа ихээхэн ялгаатай учир энд түүний тухай авч үзсэнгүй. Тухайлбал нэг хүнд ноогдох нийгмийн нийт бүтээгдэхүүний хэмжээ 1985 оны байдлаар Индонезод—533; Малайзд-2004; Сингапурт— 6179, Тайландад—740; Филиппинд — 596, харин Брунейд 25600 америк долларт хүрч байв.

1960-1984 онд АСЕАН-ны орнуудад нэг хүнд ноогдох бүтээгдэхүүн дунджаар 5,8, түүний дотор Сингапурт 7,5, Малайзид 6,1, Тайландад 5,1, Индонезид 4,6, Филиппинд 1,9 дахин өссөн нь «гуравдахь ертөнцийн» орнуудаас ихээхэн дээгүүр байна. Түүгээр үл барам 1960 онд хөгжингүй капиталист орнууд ба АСЕАН-ны орнуудын нэг хүнд ноогдох бүтээгдэхүүний хэмжээ 17,1 дахин бага байснаа 1984 онд 6,2 дахин бага болж ялгаа нь мэдэгдэхүйц багаслаа. Хэдий тийм ч АСЕАН-ны орнуудын хоорондын ялгаа жараад оныхоос багасаагүй харин чихсэх төлөвтэй байна. Дурьдсан үзүүлэлтээр 1984 онд Сингапур Индонезоос 19, Филиппинээс 9,5, Тайландаас 9,2 Малайзаас 3,5 дахин илүү байв. Тэгвэл харьцуулах үзүүлэлт 1960 онд 11,4; 2,5; 6,2; 2,9 дахин зөрөөтэй байжээ. Энэхүү тооны зөрөөний цаана чанарын ялгаа, бүтцийн өөрчлөлт дагалдаж байгаа тул тэдгээрийг тодруулах нь АСЕАН-ны орнуудын үйлдвэржүүлэлтийн үйл явцыг ойлгоход тус дөхөм үзүүлэх нь эргэлзээгүй.

Салбарын ба бүтцийн өөрчлөлт. АСЕАН-ны орнуудын үйлдвэржүүлэлтийн нэгэн гол онцлог бол хүнд ба хөнгөн аж үйлдвэрийн харьцааны өөрчлөлт бөгөөд хөнгөн үйлдвэрээс хүнд үйлдвэр рүү шилжих шилжилт явагдаж буйг дараахь хүснэгтээс харж болно.

АСЕАН-ны орнуудын хүнд, хөнгөн үйлдвэрийн харьцааны өөрчлөлт⁴

	хөнгөн		хүнд	
	60-аад оны эхэнд	80-аад оны эхэнд	60-аад оны эхэнд	80-аад оны эхэнд
Индонез	86,3	57,8	13,7	42,2
Малайз	60,5	53,9	39,5	46,1
Сингапур	55,2	21,8	44,8	78,2
Тайланд	76,9	61,4	23,1	38,6
Хөгжиж буй орнууд	58,4	48,2	41,6	51,8
Хөгжингүй кап. орнууд	34,6	32,6	69,3	67,4

Түүрүүнд өгүүлснээр АСЕАН-ны орнуудын нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний ялгаа ихсэж байсан бол наяд оны эхэн үе гэхэд гадаад, дотоод, объектив, субъектив олон орчин зүйлсийн нөлөөгөөр Индонез, Малайз, Тайланд, Филиппины аж үйлдвэрийн бүтэц хүнд ба хөнгөн аж үйлдвэрийн салбарын ангиллаар улам бүр төсөөтэй болжээ. Харин Сингапурын аж үйлдвэрийн бүтэцэд бүр 60 аад оны эх гэхэд хүнд үйлдвэр зохих байр сууриа олсон учир АСЕАН ны гишүүн орнуудтайгаа бус, хөгжингүй капиталист орнуудтай адилаартай байна. Ерөнхийдөө АСЕАН-ны орнууд хүнд үйлдвэржүүлэлтийн төвшинөөр дэлхийн хоёрдугаар дайны өмнөх капиталист орнуудын төвшинд байна гэж олон улсын мэргэжилтнүүд, эдгээр улсын эрдэмтэд үзэцгээж байна.

АСЕАН-ны орнуудын үйлдвэржүүлэлтийн хамгийн гол үр дүн бол бүтцийн өөрчлөлт бөгөөд тэдгээр орны боловсруулах үйлдвэрийн бүрэлдэхүүнд хүнс, тамхины уламжлалт салбарын хувийн жин аажмаар буурч, нэхмэл, савхин эдлэл, нефть, хими, машин, металл боловсруулах үйлдвэрийн хувийн жин мэдэгдэм нэмэгдэж, үндэсний эдийн засагт нь байр сууриа олсон явдал мөн. Тухайлбал наяд оны эхээр тухайн орнуудын нефть, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт аж үйлдвэрийн цэвэр бүтээгдэхүүнд эзлэх хувийн жин Индонезид 14,2, Малайзид 10, 1, Сингапурт 22,5, Тайландад 11,6, Филиппинд

21,0 хувьд хүрвэв. Жараад оны эхэнд машин, металл боловсруулах үйлдвэр АСЕАН-ны орнуудад үүслийн төдий байсан бол наяд оны эхэнд шинэ салбарын эзлэх хувийн жин Индонезид 21,7 Малайзид 28,6, Сингапурт 44,7, Тайландад 15,3, Филиппинд 10,7 хувьд хүрснийг дурьдахад хангалттай. Ийнхүү АСЕАН-ны орнууд хүнс, тамхины үйлдвэр зонхилсон салбарын бүтцээс машины үйлдвэр, металлург, нефть, хими мөн мод боловсруулах үйлдвэр давамгайлсан салбарын бүтцэд шилжив. Үүний үр дүнд нийт аж үйлдвэрийн цэвэр бүтээгдэхүүнд аль нэгэн салбарын эзлэх хувийн жин өөрчлөгдөөд зогсохгүй, хамгийн гол нь бүтцийн өөрчлөлт явагдах болсонд хэргийн учир оршино. Үүнийг дараахь хүснэгтээс харъя.

**АСЕАН-ны орнуудын боловсруулах үйлдвэрийн бүтэц,
зориулалтаараа {хувиар-}⁵**

	он	Хэрэглээний зориулалттай таваар	Засварын зориулалттай таваар	Удаан эдэлгээтэй буюу хөрөнгө оруулалтын зориулалттай таваар
Индонез	1970	74	21	5
	1982	45	33	22
Малайз	1960	43	40	17
	1982	37	36	27
Сингапур	1963	37	41	22
	1983	17	30	53
Тайланд	1963	66	25	9
	1980	58	24	18
Филиппин	1961	52	34	14
	1981	53	33	14
Хөгжиж буй орнууд	1963	49	30	21
	1980	39	34	27
Хөгжингүй кап. орнууд	1963	24	30	46
	1980	20	30	50

Жараад оны үед АСЕАН-ны орнуудын үйлдвэржүүлэлтийн эцсийн үр дүн хэрэглээний зүйлсийн үйлдвэрлэлээр тодорхойлогдож байсан бол эдүгээ завсрын болон эцсийн бүтээгдэхүүн, удаан эдэлгээтэй болон хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглах тийм зүйлсийн үйлдвэрлэл давуутай болсноор илэрхийлэгдэж байна. Энэ бол чухал ололт амжилт мөн. Гэвч Сингапураас бусад орны аж үйлдвэржүүлэлт нь хөгжингүй капиталист орнуудынхтай харьцуулахад ихээхэн доогуур, бүтцийн өөрчлөлт бүрэн явагдаагүй, шилжилтийн шинжтэй болох нь илэрхий. Гэхдээ ийм байдал нь АСЕАН-ны орнуудын үйлдвэржүүлэлтийн туршлагын ач холбогдлыг огтхон ч бууруулахгүй, харин ч өндөр хөгжилтэй капиталист орнуудынхаас дутахгүй ач холбогдолтой юм.

Үйлдвэржүүлэлтийн сургамж: АСЕАН-ны орнуудын үйлдвэржүүлэлт нь тус бүс нутгийн төдийгүй нийт хөгжиж буй орнуудын хувьд ихээхэн сургамжтай юм. Тэдгээрийн заримаас онцлон дурьдвал: **нэгдүгээрт**, АСЕАН-ны орнуудын аж үйлдвэрийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаагийн үрээр хөрөнгө оруулалтын хэмжээ ч, үр ашиг нь ч дээшилсээр ирэв. Жишээлбэл 1960—1962 онд АСЕАН-ны орнууд нийгмийн нийт бүтээгдэхүүнийхээ 15,2 хувийг хуримтлалд зарцуулж байсан бол 1982—1984 онд 29,8 хувийг (Үүний 26,2 хувьд дотоодын хуримтлал, 3,6 хувь нь гадаадаас орж ирсэн капитал болно) нь зарцуулж байв⁶. **Хоёрдугаарт**, АСЕАН-ны орнууд нь шинжлэх ухааны

зарцуулалт ихтэй, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарын хөгжилд ихээхэн анхаарал тавьсан явдал тэдгээр орны үйлдвэржүүлэлтийн нэгэн содон шинж мөн. Тухайлбал электроникийн үйлдвэрлэл нь наяд он гэхэд Малайзын машины үйлдвэрийн цэвэр бүтээгдэхүүний гуравны хоёр, Сингапурт 55, Филиппинд 88, Индонезид 37, Тайландад 20 хувийг өгч байв. Түүгээр үл барам 1981 — 1982 онд Сингапурын аж үйлдвэрийн экспортын 32,5, Малайзын 39,5, Тайланд, Филиппин, Индонезийн аж үйлдвэрийн экспортын 5,8— 14,5 хувийг электрон техник эзэлж байв. Мөн түүнчлэн 1970 он гэхэд Малайзид жилдээ 80-аад загварын 18,0 мянган хөнгөн тэрэг хийх хүчин чадалтай 6 угсралтын завод,⁷ Тайландад 70 загвараар 36,0 мянган машин үйлдвэрлэх 12 завод⁸ ажиллаж байв. Машин, металлург, нефть, химийн үйлдвэрийг дагалдан дэлхийн стандартын түвшинд хүрсэн олон нэр төрлийн бүтээгдэхүүн (1981 оны байдлаар нефть, химийн 15—37, машины үйлдвэрийн 8—39 нэрийн) үйлдвэрлэж байна. Энэ нь дэлхий дахины стандарт, нэр төрөлтэй харьцуулахад цөөвөр боловч, тухайн орнууддаа маргашгүй ахиц дэвшил юм.

Гуравдугаарт, АСЕАН-ны орнуудын үйлдвэржүүлэлт нь хөдөө аж ахуйн салбарынхаа хөгжлийг саатуулаагүй, харин тэнд «ногоон хувьсгал» өрнөх нөхцөлийг бүрэлдүүлж өгсөн болно. АСЕАН-ны орнуудад химийн бордооны үйлдвэрлэл үлэмж нэмэгдэн, түүний улмаас 1 га-гаас авах зөвхөн цагаан будааны ургац 60-аад оны эхэн үеэс наяд оны эхэнд Индонезид 17,6—38,2 ц, Филиппинд 12,6—24,5 ц болов.

Үүний зэрэгцээ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дахин боловсруулалт (үйлдвэрийн аргаар) Малайзид 67,4, Сингапурт 42,2, Филиппинд 41,3, Тайландад 52,0 хувьд хүрэв,⁹

Дөрөвдүгээрт, АСЕАН-ны орнууд импорт оруулах талаар ихээхэн анхаарал тавьсаны ачаар зах зээлийн дотоод багтаамжаа нэмэгдүүлж, импортын бүтцээ ихээхэн өөрчилж чадсан юм. Жишээлбэл: АСЕАН-ны орнуудын хоорондын худалдаа 1968 онд 700,8 сая доллар байсан бол 1984 онд 154 19,6 сая доллар буюу 22,9 дахин нэмэгдэв. Нийт дүнгээрээ АСЕАН-ны орнуудын худалдаа үлэмж нэмэгдсэн ч гадаад худалдааны эргэлтэд эзлэх хувийн жин нь 14,9—20,0 нэгжид л хүрэв.

АСЕАН-ны орнуудын импортын бүтэц¹⁰

	Хэрэглээний		Үйлдвэрлэлийн	
	1960	1984	1960	1984
1. Индонез	59,5	41,6	19,5	58,5
2. Малайз	51,8	30,7	48,1	69,3
3. Сингапур	77,2	52,8	22,8	47,2
4. Тайланд	46,8	49,3	53,2	50,7
5. Филиппин	36,7	71,4	63,3	28,6

АСЕАН-ны орнууд (Филиппинээс бусад) хэрэглээний бус үйлдвэрлэлийн зориулалттай зүйлийг толлон импортлон авах болсон нь хүснэгтээс харагдаж байна.

Тавдугаарт, АСЕАН-ны орнууд нэг талаас өөр хоорондын, нөгөө талаас хөгжингүй капиталист орнуудтай эдийн засгийн харилцаагаа

өргөжүүлсээр ирсэн нь тэдний үйлдвэржүүлэлтэд эерэгээр нөлөөлсөн юм.

АСЕАН-ны орнууд үндэснийхээ зах зээлийг хөгжиж байгаа болон хөгжингүй капиталист орнуудтай ойртуулахын тулд чөлөөт худалдааны бүс байгуулах, гаалийн болон эдийн засгийн холбоо тогтоох, нэгдсэн зах зээл бий болгох 4 чиглэлгээр хүч чармайлтаа төвлөрүүлж иржээ. Үүний үрээр АСЕАН-ны орнууд дэлхийн аж ахуйн хэлхээ холбоонд өргөн оролцох, нэгэн төрлийн «нээлттэй» эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж чадсан байна. АСЕАН-ны орнуудын гадаад харилцааны «газрын зургийг» ажиглахад 1984 оны үзүүлэлтээр экспортод нь Японы эзлэх хувийн жин 23,8, АНУ, Канадынх 21,8, Баруун Европын капиталист орнууд 11,3, хөгжиж буй орнууд 40,2-ыг импортод нь харьцуулах үзүүлэлт 21,1, 17,4, 14,1, 40,4 байв.

Энэ нь АСЕАН-ны орнуудын эдийн засаг нийтдээ, үйлдвэржүүлэлт тэрүүхэндээ өрнөдөөс ихээхэн хамааралтай болохыг гэрчилж байна.

Зургадугаарт, АСЕАН-ны орны үйлдвэржүүлэлтийг дагалдан хотын хүн ам, тэр дундаас ажилчин ангийн эгнээ түргэн өсч, эдийн засгийн идэвхтэй хүн амын нэлээд нь (1980-аад оны байдлаар хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид нь Индонезид 53, Малайзид 37,7, Сингапурт 0,7, Тайландад 66,0, Филиппинд 46,6 хувийг эзлэж байв)¹¹ үйлдвэр үйлчилгээний салбарт ажиллах болсон нь зөвхөн ажил эрхлэлтийн өөрчлөлтийг илэрхийлээд зогсохгүй нийгмийн бүтцэд гарсан өөрчлөлтийг давхар харуулж байна.

Үйлдвэржүүлэлтийн зөрчил, бэрхшээл. АСЕАН-ны орнуудын үйлдвэржүүлэлт нь өө сэвгүй, шулуун шууд үйл явц бус, харин ч ихээхэн бэрхшээл, зөрчил, тэмцэлтэй тулгарч байсан, тулгарсаар байгааг дурьдахгүй өнгөрч болохгүй. Энэ дашрамд тэдгээрийн дотроос хоёр чухал зүйлийн талаар цухас дурьдая.

	Гадаад өр (тэрбум доллар)		Түүний төлбөрийн экспортод эзлэх хувь	
	1970	1986	1970	1986
1. Индонез	2,9	40,9	7,9	29,8
2. Малайз	0,4	17,7	3,7	14,0
3. Сингапур	0,2	1,8*	0,6	2,4*
4. Тайланд	0,7	16,3	3,4	24,6
5. Филиппин	1,5	27,0	7,3	20,8

*Зөвхөн улсын баталгаат өрийн хэмжээ

Хүснэгтээс АСЕАН-ны орнуудын гадаад өр зогсоо зайгүй нэмэгдэж, түүний төлбөрт экспортынхоо үлэмж нөөцийг зарцуулж байгаа нь харагдаж байна.

Хоёр дахь нь гэвэл АСЕАН-ны орнууд өөр хоорондоо хийгээд хөгжиж байгаа ба капиталист орнуудтай харилцахдаа гаалийн зохицуулалт хийх, дэлхийн зах зээлд гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалах, харилцан ашигтай программ, боловсруулан Япон, АНУ-аас валютын тусламж авах зэргээр идэвхи чармайлт тавьж байна. Гэвч тэдгээрийн хэрэгжилт тун тааруу, нэг талаас орон нутгийн хөрөнгөтнүүд, нөгөө талаас үндэстэн дамнасан корпороцуудын зүгээс шахалт дарамт үзүүлж, албан ёсны засгийн газрын бодлогыг саатууж, тэгснээрээ АСЕАН-ны орнуудын үйлдвэр

жилтийн үйл явцыг улам бүр бэрхшээл, зөрчилтэй, нарийн төвөгтэй болгож байна.

АЖ АХУЙН ШИНЭТГЭЛ, НЭЭЛТТЭЙ БОДЛОГЫН ХУУЛЬ ЭРХИЙН АСУУДАЛ

Д. Шүрхүү

1978 оны III бүгд хурлаас хойш ХКН хүч анхаарлаа «дөрвөн шинэчлэлт»-ийг хэрэгжүүлэхэд төвлөрүүлж, аж ахуйг удирдах систем, эрхлэх арга барилд эрс шинэтгэл хийж, гадаад эдийн засгийн үйл ажиллагаагаа идэвхжүүлэх шийдвэр гаргасан билээ. Энэхүү чиг шугамыг 1982 онд хуралдсан ХКН-ын XI их хурлын шийдвэр, мөн онд баталсан шинэ Үндсэн хуулинд тодорхой тусгаж хуульчлан баталсан нь эрхзүйн үзэл суртлын гол чиглэл, БНХАУ-ын хууль тогтоомжийн тулгуур үндэс болсон юм.

Сүүлийн таван жилд гаргасан 50 орчим хууль тогтоомжийн тэн хагасыг аж ахуйн холбогдолтой хууль дүрэм эзэлж байгаа боловч өнөөгийн эрэлт шаардлагаас хол хоцорч байна¹. Ойрын хугацаанд 80 гаруй хуулийг бэлтгэн гаргахаар төлөвлөж байгаагийн дотор төсөв, банкы үйл ажиллагаа, төмөр зам, далайн худалдааны тухай зэрэг аж ахуйн 30 гаруй хууль орсон байна.²

Сүүлийн жилүүдэд амины болон хувийн аж ахуй эрчимтэй хөгжих болов. 1987 оны байдлаар 12 сая амины аж ахуйд 20 сая, 225 мянган хувийн аж ахуйд 3,6 сая хүн ажиллаж байв. Энэ нь нийгмийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зах зээлийг өргөжүүлэн, хүн амыг ажлаар болон хэрэгцээт бараа үйлчилгээгээр хангахад чухал үүрэг гүйцэтгэж, нийт социалист эдийн засагт үр ашигтай туслалцаа үзүүлж байгаа юм. Гэвч БНХАУ-ын Үндсэн хуульд хувийн өмчийн талаар ямар ч заалт байхгүй, аж ахуйгаа хөгжүүлэх хуульзүйн баталгаагүйн улмаас хувийн аж ахуйтнууд одоогийн бодлого өөрчлөгдөхөөс болгоомжлон, хөрөнгө мөнгө байвч үйлдвэрлэлээ өргөтгөлгүй, хүлээх аястай болжээ.

1. МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал УБ, 1988. 23 дахь тал
2. World Development Report, 1982. World Bank Wash 1982. p 112-113
3. UN, National Accounts Statistics Analysis of Main Aggregates, 1983/1984
4. UN Statistical Yearbook for Asia and the Far East Statistical Yearbook for Asia and pacific Bangkok. Various Editions, industrial Development Review Series, Thailand. Doc. UNIDO/is 5487. August 1985. p 15
5. UN Statistical Yearbook 1976, 1982. No 4. 1977, 1985
6. World Development Report 1980-1987
7. Lim. D. Economic Growth and Development in West Malaysia 1947-1970. Kuala Lumpur. 1973. p 258
8. Doc. UNlpo/s 548,7 August 1985. p 20
9. FAO production Yearbook 1973. p. 46-47. 1984. p 112-113. FAO Monthly Bulletin of Statistic 1986. vol 9 No 3 p 17
10. UN, Statistical Yearbook for Asia and the pacific 1984 Bangkok. 1986
11. ILO, Yearbook of Labour Statistics 1986. Geneva. 1986